

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр

дугаар 26/20

Дархан –Уул аймаг

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга томилох тухай

Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 04 дугаар сарын 12-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. 2026 оны 04 дугаар сарын 12-ны өдрөөс Дархан нэхий ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Эрдэнэдалай овогтой Батсайханыг томилсугай.

ХУРЛЫН ДАРГА



Р. СҮМБЭНХҮҮ

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр

дугаар 26/21

Дархан –Уул аймаг

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүтэц, зохион байгуулалт,
ажил үүргийн хуваарь, хороодын бүрэлдэхүүнийг батлах тухай

Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 04 дугаар сарын 12-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2 дахь шийдвэртэй холбогдуулан **ТОГТООХ нь:**

1. Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар Хаймчиг овогтой Нарантуяаг улируулан томилсугай.
2. Дархан нэхий ХК-ийн ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт, ажил үүргийн хуваарь, хороодын бүрэлдэхүүнийг хавсралт 1-д зааснаар тус тус баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д. БАТСАЙХАН

Дархан нэхий ХК-ийн
26 оны 26/1 тоот тогтоо
Тогтоол
удирдах
хэргэд
ээс эрэгтэй 5, эмэгтэй 4.
Дархан-уул аймаг
ТТН404 о. 2610474

2. ТУЗ-ийн дэргэдэх хороод:

2.1.1. Бүтэц: хараат бус 2, хараат 1 гишүүн бүгд 3 гишүүн.

- ### 2.1.2. Үүрэг

- 2.1.2.2. 81.5.2. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчийн ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага, харин хараат бус гишүүний хувьд энэ хуулийн 79.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх;

- 2.1.2.3.81.5.3. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд шууд нэр дэвшүүлэх;

- 2.1.2.4. 81.5.4. төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын гишүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

- 2.1.2.5. 81.5.5. гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээний нөхцөлийг боловсруулах;

- 2.1.2.6. 81.5.6. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээс бусад компанийн эрх бүхий албан тушаалтны ажлын гүйцэтгэлд гүйцэтгэх удирдлагаас өгсөн үнэлгээнд дүгнэлт гаргах;

2.2.1. Бүтэц: хараат бус 2, хараат 1 гишүүн бүгд 3 гишүүн.

- ### 2.2.2. Үүрэг

- 2.2.2.1. 81.6.1. компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

- 2.2.2.2. 81.6.2. төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтанд олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулах;

- 2.2.2.3. 81.6.3. компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж, үр дүнг үнэлэх.

2.3.1. Бүтэц: хараат бус 2, хараат 2 гишүүн бүгд 4 гишүүн.

- ### 2.3.2. Үүрэг

- 2.3.2.1. 81.4.1. компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих;

- 2.3.2.2. 81.4.2. дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах;

2.3.2.3. 81.4.3. аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах;

2.3.2.4. 81.4.4. их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах;

2.3.2.5. 81.4.5. компанийн дүрэмд заасан болон төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал/

3. ТУЗ-ийн цалин хөлс, урамшуулал:

- 3.1. ТУЗ-ийн гишүүд сар бүр хурлын 200 000 төгрөгийн хөлсийг оролцоогоор хувь тэнцүүлэн авна.
- 3.2. Байнгын ажилтай ТУЗ-ийн дарга болон хороодын дарга, ТУЗНБДарга нар батлагдсан цалинтай байна. Цалин ажлын үр дүнтэй уягдсан байна.
- 3.3. Харин гүйцэтгэх албан тушаал давхар эрхэлдэг гишүүд зөвхөн ТУЗ-ийн хурлын хөлс авна.
- 3.4. Тодорхой ажил гүйцэтгэх гэрээ хэлцэл болон өөрийн ажлаас гадуур компанид оруулсан үр ашгиас урамшуулал авна. Энэ нь ТУЗ-ээр батлагдсан байна.
- 3.5. ТУЗ-ийн цалин хөлс, урамшууллыг тооцохдоо ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын хэрэгжүүлэх заавар №01 –ээр зохицуулагдана.

4. ТУЗ-ийн гишүүдийн хороодын хуваарь:

- 4.1. Нэр дэвшүүлэх хороо: дарга хараат гишүүн Б. Гэрэлмаа, гишүүд: хараат бус гишүүн Б. Бурмаа, М. Оюунчимэг,
- 4.2. Цалин урамшуулалын хороо: дарга, хараат гишүүн Б. Гэрэлмаа, гишүүд: хараат бус гишүүн Б. Бурмаа, М. Оюунчимэг
- 4.3. Аудитын хороо: дарга, хараат бус гишүүн М. Ганзориг, гишүүд: хараат бус гишүүн Р. Бямбадорж, М. Оюунчимэг, хараат гишүүн Р. Сүмбэнхүү

5. ТУЗ-ийн байнгын ажилтнуудын ажлын цагийн хуваарь, тэдгээрийн хариуцах ажил үүрэг:

- 5.1. ТУЗ-ийн дарга
 - 5.1.1. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын ТУЗ-ийн даргын үүрэгт тусгагдсан ажлууд /ажлын цаг чөлөөт, сарын эхний 7 хоногт ажлын байранд ажиллана. Бусад үед зайнаас ажиллаж болно./ Хороодоос ирүүлсэн дүгнэлтийг үндэслэн ТУЗ-ийн тогтоол шийдвэрийг гаргаж, хэрэгжилтэд хяналт тавина.
 - 5.1.2. ТУЗ-ийн гишүүдийн ажлыг дүгнэнэ, чиглэл өгнө, ажлын төлөвлөгөөг батлана.
 - 5.1.3. Бодлогын зохицуулалт хийнэ.
- 5.2. ТУЗ-ийн НБД /хагас цагаар/ – хуулинд заасан үүрэг, ТУЗ-ээр болон хороодоор хэлэлцүүлэх материалыг нэгтгэн хурлаар оруулах, ТУЗ болон хороодын хурал зохион байгуулах, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох этгээдэд мэдээлэх, ТУЗ-бичиг хэргийг цэгцлэх, хадаглах, архивлах, ТУЗ-ийн төсвийн зардлыг хариуцан тайлагнах
- 5.3. Аудитийн хорооны дарга
 - 5.3.1. Компанийн хуулинд болон Аудитын хорооны журамд заасан үүрэг гүйцэтгэж компаниудын санхүүгийн хяналт, эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлж, комплайнсын нийцлийг хангаж ажиллах үүрэгтэй.
 - 5.3.2. ТУЗ-ийн даргын ажлыг ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу дүгнэнэ.
- 5.4. Бусад хороод хорооны журамд заасан үйл ажиллагааг хариуцна. Ажлын чөлөөт цагийн хуваарьтай.